



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 293

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4, 6.4.6, 6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 6 (зургаан) нэрийн нийт 68,584,016.80 (жаран найман сая таван зуун наян дөрвөн мянга арван зургаан төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал С.Энхцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРАНГЭРЭЛ

000415

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн
293 дугаар тогтоолын хавсралт

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ/хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Нугалааны машин /Л40/	1/5/2008	51,064,151.00	1	51,064,151.00
2	Сортлогч машин /учида/	1/5/2008	12,225,350.00	1	12,225,350.00
3	Хэвлэхийн хавтан шарах рам	6/5/2008	1,250,000.00	1	1,250,000.00
4	Принтер /лазержит 2420/	5/10/2009	1,322,333.80	1	1,322,333.80
5	Зөөврийн компьютер /ноутбуук могул/	9/22/2011	399,000.00	5	1,995,000.00
6	Зөөврийн компьютер /ноутбуук асер 4738 НҮБ/	7/1/2012	727,182.00	1	727,182.00
	Нийт дүн				68,584,016.80 (жаран найман сая таван зуун наян дөрвөн мянга арван зургаан төгрөг наян мөнгө)